

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙГ УЛСЫН ХИЛЭЭР ИМПОРТЛОХ ҮЕД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Дагалдах баримт бичиг		Хууль тогтоомж, стандартын заалт	Баримт бичигт тавигдах шаардлага	ААНБ-аас баримт бичгийг шаардах хугацааны давтамж
	Нэр	Ямар байгууллагаас олгох			
1	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тэдгээрийн түүхий эд импортлох тусгай зөвшөөрөл	УУЯ	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 15.10.4, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль 12.1	-Эх хувь	Хуулбарыг импортлох тухай бүр
2	Импортлох бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ гзаасан зөвшөөрөл	УУЯ		-Эх хувь	Хуулбарыг импортлох тухай бүр
3	Худалдааны гэрээ	-	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль 12.3.3.	-Эх хувь	Гэрээний хугацаанд 1 удаа
4	Гарал үүслийн эсвэл чанарын гэрчилгээ	Экспортлогч талын эрх бүхий байгууллага	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль 12.2, 11.1.3	-Эх хувь	Импортлох тухай бүр
5	Тээврийн гэрээ(автозам), гэрээнд холбогдох мэдээллийг хавсаргасан		Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль 12.3.3, 14.3	-Эх хувь	Гэрээний хугацаанд 1 удаа
6	Аюултай ачааны ослын карт	-	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 3.1.1.2, 3.1.1.3	-Эх хувь	Импортлох тухай бүр шаардах ба тухайн баримт бичгүүд нь ачаа, барааг дагалдаж яваа эсэхийг шалгаад аж ахуйн нэгж, байгууллагад буцааж өгнө
7	Аюултай ачааны тээвэрлэлтийг хариуцаж яваа ажилтан болон хамгаалалтын хүмүүс тухайн ачааг дагалдаж яваа болохыг гэрчилсэн баримт, гэрчилгээ	-	Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм 36, Аюултай ачаа. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4978:2000 стандарт 6.20	-Эх хувь -Тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцаж ажиллах эрхийн үнэмлэхийг шалгана. -тээврийн хэрэгслийн замын хуудсанд овог нэрээ тэмдэглүүлсэн эсэхийг шалгана.	Импортлох тухай бүр шаардах ба тухайн баримт бичгүүд нь ачаа, барааг дагалдаж яваа эсэхийг шалгаад аж ахуйн нэгж, байгууллагад өгнө

Нэмэлт мэдээлэл: Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг Засгийн газрын 2006 оны 149, 2007 оны 66, 2010 оны 80 дугаар тогтоолоор тус тус батлагдсан Дорноговь аймгийн Замын-Үүд, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Сүхбаатар, Дорнод аймгийн Баянхошуу, Сүхбаатар аймгийн Бичигт, Өмнөговь аймгийн Гашуунсүхайд, Улаанбаатар дахь олон улсын агаарын замын “Чингис хаан” боомт (тээвэрлэлтийн үеийн аюулгүй нөхцөлийг хангасан тохиолдолд)-оор тус тус нэвтрүүлнэ.

Дээрх зааснаас бусад шаардлагыг № 9.4.2 кодтой Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох үеийн хяналтын хуудас болон Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Аюултай ачаа. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4978:2000 стандартаас харна уу.